

Эрдэс баялгийн төлбөрийн орлого хариуцсан мэргэжилтэн, Батжаргал Энхсайхан
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгаж, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэгдүгээр хавсралтаар батлагдсан. Энэ хүрээнд Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай нэгдсэн төсвийн орлого, зарлага болон хөрөнгө оруулалтын өмнөх онуудын гүйцэтгэл, нөхцөл байдлын дүн шинжилгээ, цаашдын чиг	3-р сар, 4-р сар, 9-р сар, 10-р сар	100%

					хандлага болон дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын талаар танилцуулгыг боловсруулж, холбогдох танилцуулгад тусган ажилласан. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг Монгол Улсын Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Хавсралт: 2 файл		
1.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах;							
2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Тооцоо, төсөөллийн тусгасан танилцуулгын тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай төсвийн өнөөгийн байдал, төсөөллийг боловсруулж холбогдох тайлан, танилцуулга боловсруулсан. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгад нэгдсэн төсвийн орлого, зарлага болон улсын төсвийн	4-р сар, 5-р сар	100%

					хөрөнгө оруулалтын 2024 оны гүйцэтгэл, 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2026 оны төсөөллийг боловсруулж, тусгасан. "Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар, холбогдох байнгын хороодоор хэлэлцсэн бөгөөд Улсын Их Хурлын хурлын чуулганы 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Дунд хугацаанд үр ашиггүй төсвийн урсгал зардлыг бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог үе шаттай багасгах төсвийн бодлогыг хэрэгжүүлэхээр холбогдох дэлгэрэнгүй танилцуулга, тэргүүлэх чиглэлд тусгасан. Хавсралт: 2 файл		
3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	2025 оны I, II улиралд дүн шинжилгээ хийж танилцуулга хамтран боловсруулж бэлдсэн байна. /2 танилцуулга/	Макро эдийн засгийн 2025 оны 1 дүгээр улирал болон 2024 оны жилийн эцсийн танилцуулга тайланг монгол болон англи хэлээр бэлтгэн, олон нийтэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар,	100%

					түгээсэн. Тус тайланд нэгдсэн төсвийн орлого, урсгал зардал болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын өсөлтөд голлон нөлөөлж буй хүчин зүйл, мөн засгийн газрын өрийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, улирлын танилцуулгад тусган боловсруулсан. Хавсралт: 3 файл	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
1.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох;							
4	Макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	"Танилцуулгын тоо"	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	Макро эдийн засгийн 2025 оны сарын тайланг тухай бүр хамтран боловсруулан бэлдэх.	Макро эдийн засгийн сарын танилцуулгад нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл болон засгийн газрын өрийн гүйцэтгэлд тухайн сар бүр дүн шинжилгээ хийж, англи болон монгол хэлээр бэлтгэн боловсруулсан. Тус сар тутмын танилцуулга нь удирдлагуудыг мэдээллээр хангаж, яамны цахим хуудсаар олны нийтэд түгээгдсэн. Хавсралт: 12 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
1.4. Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгааг бодлогын хөгжүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах;							
5	Дата боловсруулж баазууд эдийн	Тайланд ашигласан тоо	-	Макро эдийн засгийн нөхцөл	Монгол Улсын нэгдсэн төсвийн тухайн жилийн	3-р сар, 9-р сар, 12-р	100%

	засгийн судалгаанд ашиглана. (Гаалийн дата, И-баримт гэх мэт)			байдлын улирлын тайланд тоон мэдээллийг ашигласан байна.	батлагдсан төсөвт тодотгол хийх нөхцөлүүдэд дүн шинжилгээ хийх хүрээнд эрдэс баялгийн үнэ, тодруулбал зэсийн баяжмал болон нүүрсний хилийн үнийн өөрчлөлт төсвийн орлого төвлөрүүлэлт болон төсвийн бусад үзүүлэлтэд хэрхэн нөлөөлж байсан талаар дүн шинжилгээг гаалийн ерөнхий газрын статистикийн дата баазаас авсан тоон мэдээлэлд үндэслэн хийж, макро эдийн засгийн улирлын тайлан, танилцуулгад тусгасан болно. Хавсралт: 4 файл	сар	
6	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлага, төрийн оролцоог үе шаттайгаар бууруулна.	танилцуулгад тусгасан байдал	-	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын шинжилгээ тоон мэдээллийг танилцуулгад тусгасан байх.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хүрээнд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдалтай уялдуулан нэгдсэн төсвийн зарлагын шинжилгээг хийсэн. Тус хуулийн төсөл болон	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

					холбогдох танилцуулгад төсвийн бодлого, зарлагын дүн шинжилгээнд үндэслэн дунд хугацаанд нийт төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2026 онд 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь байхаар үе шаттайгаар буурахаар тооцоолон тусгав. Мөн энэ хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т заасны дагуу нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх хуулийн шаардлагыг хангаж байхаар урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24 хувь, 2027 онд 23 хувь, 2028 онд 22 хувь тус тус байхаар тооцоолон, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөлд тусган боловсруулсан. Хавсралт: 2 файл		
1.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх;							

7	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг холбогдох хууль, журамд заасны дагуу олон нийтээр хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулна	Хэлэлцүүлэг зохион байгуулсан тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн	Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027- 2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа Төсвийн тухай хуульд заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Туушин зочид буудалд амжилттай хамтран зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийн үеэр ирүүлсэн төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэд болон бусад төлөөллөөс ирүүлсэн саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн танилцуулгад тусгасан. Хавсралт: 3 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 12-р сар	100%
8	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	Макро эдийн засгийн нөхцөл байдал, 2026-2028 оны тооцоо, төсөөллийн танилцуулгыг	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар	100%

	эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.			боловсруулсан байна/ 1 танилцуулга/	макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тооцоолол, төсөөлөл болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн холбогдох таамаглалд үндэслэн төслийн орлого, зарлага болон өрийн тооцоолол, төсөөллийг боловсруулж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөл, танилцуулгад тусгасан. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024.04.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 19 дүгээр тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу 2024.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
--	---	--	--	-------------------------------------	--	---	--

					мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, 2025 оны 5 дугаар сарны 30-ны өдөр баталсан. Хавсралт: 3 файл		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байна	-	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, хөгжүүлэх мэдлэгээ дээшлүүлэх	Төрийн албаны тухай хууль, төсөв, банк санхүүгийн салбарын холбогдох хууль, дагалдах хууль тогтоомж болон хуулийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж, мэдлэгээ дээшлүүлсэн. ОУВС-ийн "Financial Market Analysis" цахим сургалтад хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

2	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа дээшлүүлсэн байх	-	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан байх	Германы олон улсын хамтын ажиллагааны хэрэгжүүлэгч байгууллага (GIZ)-ийн "Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих" (ICED) төслийн хүрээнд төслийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлт, 2025 оны төлөвлөгөөнд тусгагдах үйл ажиллагааны чиглэлийг дүгнэн хэлэлцэх тайлангийн хурал, Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх сургалт, семинарт хамрагдсан. Мөн газар, хэлтсийн чиг үүрэгт хамаарах дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулж, оролцсон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	--	---	---	---	--	---	------

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж /...../

Огноо: 2025.06.25

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрдэс баялгийн төлбөрийн орлого хариуцсан мэргэжилтэн, Батжаргал Энхсайхан /...../

Огноо: 2025.06.25

